Нэхэмжлэгч “Бялхам-Ерөөл” ХХК нь хариуцагч Жаргалант гурван мөнх хоршоонд холбогдуулан газар албадан чөлөөлүүлэх, эд хөрөнгөд учруулсан хохиролд 61,321,200 төгрөг, түрээсийн орлогын 30 хувь болох 30,300,000 төгрөг, үндэслэлгүй хөрөнгөжсөн 800,000 төгрөг, хамгаалалтын албаны зардал 15,400,000 төгрөг, нийт 107,821,200 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасныг хариуцагч Жаргалант гурван мөнх хоршоо нь эс зөвшөөрч, нэхэмжлэгч “Бялхам-Ерөөл” ХХК-д холбогдуулж гэрээний үүрэг зөрчсөнөөс учирсан хохиролд 296,320,137.93 төгрөг гаргуулах тухай сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг гаргажээ.